



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 09 сарын 22 өдөр

Дугаар 458

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 97,991,750.00 (ерэн долоон сая есөн зуун өрэн нэгэн мянга долоон зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 94,375,083.18 (ерэн дөрвөн сая гурван зуун далан таван мянга наян гурван төгрөг арван найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Сэлэнгэ аймгийн Газрын харилцаа, барилга, хот, байгуулалтын газрын дарга Б.Саруултөгс нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөөт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА *Д.Нарангэрэл* Д.НАРАНГЭРЭЛ

900879

Төрийн өмчийн бодлогоо, зохицуулалтын газрын
2020 оны 09 дугаар сарын 08-ны өдрийн
10 дугаар тогтоолын хавраамт

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины нэр, марк, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Ху蕊мтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Прадо-76, 70-71СЭҮ (арал-КМЛШН7.ЈРУ747071)	2013/2015	263545	82,491,750.00	82,491,750.00	-	3,000,000.00
2	Старекс, 97-41 СЭА (арал-јеew7.1j607021471)	2007/2016	195781	15,500,000.00	11,883,333.18	3,616,666.82	3,700,000.00
	Нийт дүн			97,991,750.00 (ерэн долоон сая есөн зуун далан таван өрэн нэгэн мянга долоон зуун тавин)	94,375,083.18 (ерэн дөрвөн сая гурван зуун далан таван мянга наян гурван төгрөг арван найман мөнгө)	3,616,666.82 (гурван сая зураган зуун арван зураган мянга зураган зуун жаран зураган төгрөг арван найман мөнгө)	6,700,000.00 (зургаан сая долоон зуун мянган)